



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/108

Хэрлэн сум

Эзэмшил газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Д.Эрхэмбаяр (ДС92022312)-ын эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг (Хэрлэн), Тариаланчид 176 гудамж 13 тоотод байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1000 м<sup>2</sup> газрыг 55 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Д.Эрхэмбаярын эзэмшил эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Д.Эрхэмбаярт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны а/310 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ